



**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2017 оны 05 сарын 10 өдөр

Дугаар A/19

Улаанбаатар хот

**Дархлаажуулалтын 10 хоногийг
зохион байгуулах тухай**

Монгол улсын засгийн газрын тухай хуулийн 24.2, Дархлаажуулалтын тухай хуулийн 12.1, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.3, 3.1.6 дахь зорилтод тусгасан “Элэг бүтэн Монгол” хөтөлбөр, Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах” үндэсний хөтөлбөр, Эрүүл мэндийн сайдын “Дархлаажуулалтын 10 хоногийг зохион байгуулах тухай” А/175 тоот тушаалыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ НЬ:

1. Дархлаажуулалтын 10 хоногийг “Хепатит В вирусын халдвараас сэргийлье” уриан дор 2017 оны 05 дугаар сарын 10-наас 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын 10 хоногийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар, вакциныг хэрэглэх зааврыг гуравдугаар, дархлаажуулалтын хамралтын мэдээний хүснэгтийг дөрөвдүгээр, дархлаажуулалтын явцад дэмжлэгт хяналт хийх хуваарийг тавдугаар, ДДУХ-ын үед арга хэмжээ авах багийг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтын 10 хоногоор “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд хепатитын В вирусын халдвар илрүүлэх шинжилгээнд сүүлийн 14 хоногийн дотор хамрагдаж, халдваргүй байгаа нь тогтоогдсон 40-65 насны иргэдийг В вирусын эсрэг сэргийлэх тарилгын эхний тунгаар, нэг сарын дараа хоёр дахь тунгаар дархлаажуулах ажлыг зохион байгуулах, Заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон 15 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулах, Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 16, 17 настай сурагчдыг Улаанбурхан, Улаанууд өвчний эсрэг вакцинаар дархлаажуулахыг Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нарт үүрэг болгосугай.

4. В вирусын эсрэг вакцинаар, Улаанбурхан, Улаанууд өвчний эсрэг вакцинаар дархлаажуулах арга хэмжээг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг дэмжлэгт хяналтын багт үүрэг болгосугай.

5. Дархлаажуулалтыг хийхэд шаардлагатай вакцин, дагалдах хэрэгслийг татан авч дархлаажуулалтын цэгүүдийг ханган ажиллахыг дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн /Д.Ичинхорлоо/-д үүрэг болгосугай.

6. Дархлаажуулалтын явц, хамралт, халдвар хамгааллын дэглэм вакцины хадгалалт, хог хаягдлын ангилал устгал зэрэгт хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

7. Дархлаажуулалтын 10 хоногоор ажилласан Хан-Уул эрүүл мэндийн төвийн эмч, ажилтнуудын илүү цагийн тооцоог бодож олгохыг ахлах нягтлан бодогч /Д.Юнгэр/-д, Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн эмч ажилтнуудын илүү цагийн тооцоог бодож олгохыг Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

8. Дархлаажуулалтын 10 хоногийн хугацаанд дархлаажуулалтын байнгын, түр, явуулын цэгүүдэд дэмжлэгт хяналтаар ажиллах багуудыг унаагаар тасралтгүй хангахыг ахлах нягтлан бодогч /Д. Юнгэр/-д даалгасугай


9. Нэмэлт дархлаажуулалтын хамралтын мэдээг өдөр бүр дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд мэдээллэж байхыг Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт үүрэг болгосугай.

10. Дархлаажуулалтын хамралтын мэдээг өдөр бүр Өрхийн эрүүл мэндийн төвүүдээс авч нэгтгэн Нийслэлийн эрүүл мэндийн газар, Халдварт өвчин судлалын үндэсний төвд мэдээллэж байхыг дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн /Д.Ичинхорлоо/-д даалгасугай.

11. Дархлаажуулалтын ач холбогдлын талаар эцэг эхчүүд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, 40-65 насны иргэдэд өргөнөөр сурталчлахыг сургалт хариуцсан мэргэжилтэнд даалгасугай.


12. Энэ тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн Эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.БОДЬЦЭЦЭГ

Хан уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 15 дугаар сарын 10 ний өдрийн
А/19. тушаалын 1 дүгээр хавсралт



ДАРХЛААЖУУЛАЛТЫН 10 ХОНОГИЙН АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Лувсанням - Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга

Нарийн бичгийн дарга:

Д.Ичинхорлоо - Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Э.Цэвэлмаа - Чанарын албаны дарга

Б.Эрдэнэсүвд - Чанарын менежер

Г.Үүрийн туяа - Өрхийн менежер

Б.Онон - Хүүхдийн ерөнхий зрхицуулагч

М.Бямбажаргал - Хүүхэд өсвөр үеийн эмч

Ө.Ариунжаргал – Тархвар судлаач

Сургалт хариуцсан мэргэжилтэн

Б.Халиунгэрэл - Сувилахуйн арга зүйч

Д.Мөнхцэцэг - Дархлаажуулалт хариуцсан сувилагч

Өрхийн эрүүл мэндийн дарга нар

Хан уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 15 дугаар сарын 10 ний өдрийн
01/19... тушаалын 2 дугаар хавсралт


ТТБ2350.Б 9120262

ДАРХЛААЖУУЛАЛТЫН 10 ХОНОГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн	Хяналт тавих хүн	Хамтран ажиллах байгууллага
Нэг. Вакцины хангалт, түгээлт					
1.1	В гепатитын эсрэг вакцин, Улаанбурхан, Улаанууд өвчний эсрэг вакцин, дагалдах хэрэгслийг захиалах	Ү/5-8	Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Ичинхорлоо	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Лувсанням	ХӨСҮТ
1.2	В гепатитын эсрэг вакцин, Улаанбурхан, Улаанууд өвчний эсрэг вакциныг хүлээн авч, хадгалах, түгээх үеийн хүйтэн хэлхээнд хяналт тавих	Ү/5-8	Дархлаажуулалт хариуцсан сувилагч Д.Мөнхцэцэг	Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Ичинхорлоо	ХӨСҮТ
1.3	В гепатитын эсрэг вакцин, Улаанбурхан, Улаанууд өвчний эсрэг вакцин, дагалдах хэрэгслийг түгээх	Ү/9-10	Дархлаажуулалт хариуцсан сувилагч Д.Мөнхцэцэг	Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Ичинхорлоо	ХӨСҮТ
Хоёр. Зохион байгуулалт					
2.1	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 16, 17 настай сурагчдын судалгааг гаргах	Ү/8-9	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нар	Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Ичинхорлоо	ХӨСҮТ
2.2	Дархлаажуулалтын 10 хоногоор хийгдэх ажлын талаар ӨЭМТ-ийн болон ЕБС-ийн эрхлэгч, эмч нарт сургалт хийх	Ү/9	Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дарга нар	Ажлын хэсэг	ЭМТөв
2.3	Дэмжлэгт хяналт хийх багт сургалт хийж дадлагажуулах	Ү/10	Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Ичинхорлоо	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Лувсанням	ХӨСҮТ
Гурав. Дархлаажуулах үйл ажиллагаа					
3.1	Заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолоос хоцорсон 15 хүртлэх насны хүүхдийг нөхөн, ЕБС-ын 16,17 настай сурагчдын улаанбурхан улаанууд өвчний эсрэг	Ү/10-20	ӨЭМТ-ийн дарга нар	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Лувсанням	ХӨСҮТ, ХУД

	хавсарсан вакцинаар дархлаажуулах				
3.2	Хепатитын В вирусийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаж, халдваргүй байгаа нь тогтоогдсон 40-65 насны иргэдийг Хепатитын В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулах ажлыг зохион байгуулах	Y/10-20	ӨЭМТ-ийн дарга нар	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Б.Лувсанням	ХӨСҮТ, ХУД
3.2	Байнгын, түр болон явуулын цэг байгуулан ажиллах	Y/10-20	ӨЭМТ-ийн дарга нар	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Б.Лувсанням	ӨЭМТ, ЕБС
3.3	Дархлаажуулалтын явц, халдвар хамгаалалын дэглэм, вакцины хадгалалт ,тээвэрлэлт, тарьж байгаа технологи, урсгал, хамралт зэрэгт дэмжлэгт хяналт хийж арга зүйгээр ханган ажиллах	Y/11-20	Ажлын хэсэг	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Б.Лувсанням	ХӨСҮТ
3.4	ӨЭМТөвүүд хамралтын мэдээг өдөр бүр цагийн хуваарийн дагуу мэдээлэх	Y/10-20	ӨЭМТөвийн дарга нар	Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Ичинхорлоо	ХӨСҮТ, НЭМГ
3.5	Дархлаажуулалтын 10 хоногийн хамралтын мэдээг нэгтгэн гаргаж мэдээг ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлэх	Y/22	Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн Д.Ичинхорлоо Дархлаажуулалт хариуцсан сувилагч Д.Мөнхцэцэг	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Б.Лувсанням	ХӨСҮТ, НЭМГ
Дөрөв. Мэдээлэл сурталчилгаа					
4.1	Дархлаажуулалтын талаар олон нийтэд мэдээлэх, сурталчилах	Y/10-20	ӨЭМТөвийн дарга нар Сургалт хариуцсан мэргэжилтэн	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Б.Лувсанням	ӨЭМТ, ЕБСургуули уд
4.2	Сайн дурын идэвхтэнг татан оролцуулах	Y/10-20	ӨЭМТөвийн дарга нар Сургалт хариуцсан мэргэжилтэн	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Б.Лувсанням	ӨЭМТ, ЕБСургуули уд
4.4	Дархлаажуулалтын 10 хоногийн талаарх мэдээллийн байгууллагын вэб сайтад байршуулах	Y/10-20	ӨЭМТөвийн дарга нар Сургалт хариуцсан мэргэжилтэн	Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга Б.Лувсанням	Мэдээллийн технологийн ажилтанууд

Хан уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 05 дугаар сарын 10 ний өдрийн
А/19 тушаалын 3 дугаар хавсралт



ХЕПАТИТ В ВИРУСЫН ЭСРЭГ ВАКЦИНЫГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

"E1)VAX B" гепатитын В вирусн эсрэг вакцин нь вирусн гадаргуугийн антиген (HBзАд)-ий халдваргүй бүтцийг хөнгөн цагааны давсанд шингээн цэвэршүүлэн гаргаж авсан вакцин юм. Тогтворжуулагч бодисоор тимеросалыг ашигласан. Хөрөнгөний эс (ЗассНаготусез сегеу|31ae)-ийн ДНХ-д рекомбинац хийх замаар вакциныг бэлтгэсэн. Уг бэлдмэл нь гепатит В вирусн эсрэг рекомбинант вакцин бөгөөд ДЭМБ-ын шаардлагыг бүрэн хангасан. Үйлдвэрлэхэд хүний эд эрхтний гаралтай ямар нэгэн бүтээгдэхүүн хэрэглээгүй болно.

Найрлага

"E1)VAX B" гепатитын В вирусн эсрэг вакцин нь цагаан, цийдмэг өнгөтэй суспензи юм. 1мл вакцинд:

- Идэвхтэй нэгдэл: Цэвэршүүлсэн HBзAg.....20мкг
- Нэмэлт бодис: Хөнгөн цагааны гидроксидын гель.....0,5мг
- Тогтворжуулагч: Тимерозал.....0,01w/v%
- Калийн фосфат 1 суурьт натрийн фосфат, 2 суурьт натрийн хлорид тус тус агуулагдана.

Хэрэглэх заалт:

Гепатитийн В вирусн бүх төрлийн дэд хэвшинжээр үүсгэгдэх халдварын эсрэг дархлал тогтоох зориулалттай. Гепатитын В вирусн эсрэг вакциныг БЦЖ, СХТ, улаанбурхан, халдварт саагийн вакцинтай нэг өдөр, нэгэн зэрэг хэрэглэж болно. Ямар нэг вакцинтай нэг өдөр зэрэг хийсэн тохиолдолд зааврын дагуу тусдаа тариураар, өөр газар тарина.

Хэрэглэх арга, тун хэмжээ:

Нэгээс дээш насны хүүхэд, насанд хүрэгсдэд гарын бугалганы (делтойд) гадна дээд хэсэгт, булчинд тарьж хэрэглэнэ.

- Хүүхдийн (15 хүртэлх насны хүүхэд) нэг удаагийн тун 0.5 мл
 - Насанд хүрэгсдийн (16-аас дээш насны хүн) нэг удаагийн тун 1.0 мл
- Вакциныг 3 удаа тарьж хэрэглэнэ.
- Эхний тун: сонгосон өдөр
 - 2 дахь тун: эхний тунгаас хойш 1 сарын дараа
 - 3 дахь тун: 2 дахь тунгаас хойш 5 сарын дараа тарина.

Хадгалалтын явцад өнгөгүй, тунгалаг цагаан тунадас үүсдэг тул хэрэглэхийн өмнө вакциныг зөөлөн, сайтар сэгсэрнэ. Хүн нэг бүрт нэг удаагийн зүү, тариур хэрэглэнэ.

Хөхүүл ба жирэмсэн эмэгтэй:

Хөхүүл эх вакциныг хийлгэж болно.

Хариу урвал.

Цөөн тохиолдолд тарьсан газар улайх, хавдах, өвдөх, бага зэрэг халуурах зэрэг хэсэг газрын шинж тэмдэг илрэх ба 2 хоногийн дотор арилна. Ховор тохиолдолд халуурах, чичрүүдэс хүрэх, бие сулрах, толгой өвдөх, нус гоожих, дотор муухайрч бөөлжих, булчин өвдөх, үе мөч үрэвсэх, арьсан дээр тууралт гарах, трансаминаза нэмэгдэх, маш ховор тохиолдолд неврит, нүдний мэдрэлийн үрэвсэл, нүүрний саа, түгээмэл хатуурал өвчин сэдрэх, Гийен-Баррын хамшинж зэрэг шинжүүд илэрч болно. Эсрэг заалт:

Дараах тохиолдолд вакциныг тарьж болохгүй. Үүнд:

- Вакцины найрлаганд орсон бодист хэт мэдрэг хүмүүст
- Цочмог халдварт өвчний үед

Өмнө нь хепатитын В вирусийн халдвартай байсан, шинээр халдвар авсан хүн уг вакциныг тариулахад эрүүл мэндэд нь сөргөөр нөлөөлөхгүй. ХДХВ-ийн халдвартай хүн вакциныг товллын дагуу хэрэглэж болно. Маш ховор тохиолдолд анафилаксийн шок өгөх магадлалтай тул 1%-ийн адерналиныг бэлэн байлгана.

Хадгалах горим:

Задалсан вакциныг $+2^{\circ}\text{C}$ - $+8^{\circ}\text{C}$ хэмд хадгална. Дараах шаардлагуудыг бүрэн хангасан тохиолдолд задалсан вакциныг 6 цагийн дотор хэрэглэж болно.

- Вакцины хугацаа дуусаагүй.
 - Вакциныг хүйтэн хэлхээний зохих нөхцөл ($+2^{\circ}\text{C}$ - $+8^{\circ}\text{C}$ хэм)-д хадгалсан.
- Дор дурьдсан шинжийн аль нэг илэрвэл задалсан вакциныг шууд устгана.
- Вакциныг задалснаас хойш зохих журмын дагуу хадгалаагүй;
 - Задалсан вакцин бохирдсон;
 - Нүдэнд харагдахуйц бохирдолтой (өнгө нь өөрчлөгдсөн, хөвмөг үүссэн).


Хадгалах нөхцөл:

$+2^{\circ}\text{C}$ - $+8^{\circ}\text{C}$ хэмд хөргөгчид хадгална. Хөлдөөж огт болохгүй.

Шошгон дээрх дөрвөлжин дүрсний өнгө түүнийг хүрээлсэн дугуй дүрсний өнгөнөөс илүү цайвар бөгөөд вакцины хэрэглэх хугацаа нь хэтрээгүй бол вакциныг хэрэглэж болно.

Харин шошгон дээрх дөрвөлжин дүрсний өнгө түүнийг хүрээлсэн дугуй дүрсний өнгөтэй адил буюу түүнээс бараан байвал вакциныг хэрэглэж болохгүй. 1 флоканд 10 хүн тунгаар савлагдсан.

Хан уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 15 дугаар сарын 10 ний өдрийн
8/19 тушаалын 4 дугаар хавсралт



ХЕПАТИТ В ВИРУСЫН ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТЫН
ХАМРАЛТЫН МЭДЭЭ

Дүүрэг

Огноо...../...../...../

Дархлаажуулсан тун/ сонгоно/: а. Эхний тун б.2 дахь тун

№	Өрхийн Эрүүл мэндийн төв	Хамрагдвал зохих хүний тоо	Хамрагдсан хүний тоо

Тайлбар: Хамралтын мэдээг өссөн дүнгээр гаргаж өдөр бүрийн 18 цагт 99001159, 95811647 утсаар болон ichko_0819@yahoo.com цахим хаягаар Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд мэдээлнэ.

УЛААНБУРХАН,УЛААНУУД ӨВЧНИЙ ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТЫН
ХАМРАЛТЫН МЭДЭЭ


Дүүрэг

Огноо...../...../...../

№	Өрхийн Эрүүл мэндийн төв	16нас			17нас			Нийт		
		Хамрагдвал зохих хүүхдийн тоо	Хамрагдсан хүүхдийн тоо	Хамралт %	Хамрагдвал зохих хүүхдийн	Хамрагдсан хүүхдийн тоо	Хамралт %	Хамрагдвал зохих хүүхдийн тоо	Хамрагдсан хүүхдийн тоо	Хамралт %

Тайлбар: Хамралтын мэдээг өссөн дүнгээр гаргаж өдөр бүрийн 18 цагт 99001159, 95811647 утсаар болон ichko_0819@yahoo.com цахим шуудангаар ХУЭМТөв дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэнд мэдээлнэ


Хан уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 05 дугаар сарын 10 ний өдрийн
17/19... тушаалын 5 дугаар хавсралт



ДДУХ-ИЙН ҮЕД АЖИЛЛАХ БАГ

1. Мэдрэлийн эмч - Ц.Чулуун
2. Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн - Д.Ичинхорлоо
3. Хүүхдийн мэргэжилтэн - Б.Онон

Хан уул эрүүл мэндийн төвийн даргын
2017 оны 05 дугаар сарын 10 ний өдрийн
А/19 тушаалын 6 дугаар хавсралт



ДЭМЖЛЭГТ ХЯНАЛТ ХИЙХ БАГИЙН ХЯНАЛТ ХИЙХ ХУВААРЬ.

№	Дэмжлэгт хяналтын баг	Дэмжлэгт хяналт хийх хугацаа, Дархлаажуулалтын цэгүүдийн хуваарь\ Байнгын, түр, явуулын\
		Ү/10-20
1-р баг	Э.Цэвэлмаа - Чанарын албаны дарга Бямбажаргал- Хүүхэд өсвөр үеийн эмч	Мөнхбадрах, Тэрмэстий, Энхтитэм
2-р баг	Б.Эрдэнэсүвд-Чанарын менежер-Сургалт хариуцсан мэргэжилтэн	Цэцдо Маналүйлс Чандавиа
3-р баг	Б.Онон-Хүүхдийн ерөнхий зрхицуулагч Үүрийн туяа Өрхийн менежер	Хашчагнуур Уясах Аяут
4-р баг	Д.Ичинхорлоо Дархлаажуулалт хариуцсан мэргэжилтэн Б.Лувсанням Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга	Аминтус Амгалан өрх Био асралт
5-р баг	Халиунгэрэл -Сувилахуйн албаны дарга Ө.Ариунжаргал-Тархвар судлаач	Туул Өлзийт Мэндсаруул Энхбуянтманал